



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/370

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны
Одонт манал өрхийн эрүүл мэндийн төвийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 13,323,929 (арван гурван сая гурван зуун хорин гурван мянга есөн зуун хорин ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны Одонт манал өрхийн эрүүл мэндийн төв (Л.Оюунчимэг)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 11 нэр төрлийн 4,193,255 (дөрвөн сая нэг зуун ерэн гурван мянга хоёр зуун тавин тав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 32 нэр төрлийн 9,130,674 (есөн сая нэг зуун гучин мянга зургаан зуун далан дөрөв) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 49,000 (дөчин есөн мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 14,700 (арван дөрвөн мянга долоон зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны Одонт манал өрхийн эрүүл мэндийн төв (Л.Оюунчимэг)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001035



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 11 дугаар сарын 01 - ны өдрийн А/370 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны Одонт манал ӨЭМТ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Эвдрэл гэмтэл	ӨХЗ-ийн дүгнэлт	Байгуулагын үнийн санал	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Хүүхдийн жин	14	ш	1	64,713	64,713	64,713	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
2	Хүүхдийн жин	13	ш	1	59,880	59,880	59,880	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
3	Хүүхдийн жин	11	ш	1	159,000	159,000	159,000	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
4	Гар гангелийн ком	12	ш	1	190,000	190,000	190,000	-	эвдэрхий	актлах	устгах	устгах
5	Хэвлийн дасгалын төхөөрөмж	12	ш	1	90,000	90,000	90,000	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
6	Хүчний дасгалын төхөөрөмж	12	ш	1	435,000	435,000	435,000	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
7	Босоо татлага	14	ш	1	124,542	124,542	124,542	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
8	Хэвтээ татлага	14	ш	1	100,122	100,122	100,122	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
9	Компьютерийн ширээ	14	ш	1	60,000	60,000	60,000	-	эвдэрхий	актлах	500	500
10	Сандал	14	ш	3	14,652	43,956	43,956	-	эвдэрхий	актлах	500	500
11	Саарал карт шүүгээ	14	ш	1	30,525	30,525	30,525	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
12	Дрож	9	м	5.5	49,000	269,500	269,500	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
13	Цагаан самбар	14	м	1	60,557	60,557	60,557	-	эвдэрхий	актлах	устгах	устгах
14	Диван ор	14	ш	1	225,885	225,885	225,885	-	эвдэрхий	актлах	устгах	устгах
15	Төмөр зуух	14	ш	1	20,000	20,000	20,000	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
16	Том сандал	14	ш	5	18,315	91,575	91,575	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
17	Ширээ	14	ш	4	134,775	539,100	539,100	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
18	Жижиг сандал	9	ш	10	18,000	180,000	180,000	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
19	Унадаг дугуй	12	ш	1	268,000	268,000	268,000	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
Тавилга, эд хогшлын дүн					3,012,355	3,012,355	3,012,355	-			15,000	15,000
20	Пульсаксометр	11	ш	1	352,000	352,000	352,000	-	эвдэрхий	актлах	устгах	устгах
21	Сахар үзэгч	13	ш	1	50,000	50,000	50,000	-	эвдэрхий	актлах	устгах	устгах
22	Гүйлтийн зам	13	ш	1	315,000	315,000	315,000	-	эвдэрхий	актлах	1,000	1,000
23	Хөлийн массаж аппарат	14	ш	1	95,000	95,000	95,000	-	эвдэрхий	актлах	1,000	1,000

